



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/111/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудит газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Батжаргал Утас: 70584207 Цахим хаяг: Batjargalb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртэл

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Менежментийн захидал	Error! Bookmark not defined.
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	9
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	9
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13



2.1. Оршил

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг **дарга Э.Жавхлан** танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу **Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын** 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Б.Батжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 24 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын эрхэм зорилго нь “Гэр бүлийн хөгжил, тогтвортой байдлыг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах болон хүүхдийн эрх хөгжил, хамгааллын үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг хангах, залуучуудын хөгжил, нийгмийн оролцоог дэмжих”-д оршино.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суурь судалгаанд үндэслэн гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих,
- Хүүхдийн эрх хамгааллын асуудлаарх төрийн бодлого, хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, сурталчлах, хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх,
- Залуучуудын хөгжил, оролцоо, манлайллыг дэмжсэн нийгмийн орчинг бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн сурталчилгаа, нөлөөлөл, хамтын ажиллагаа,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acoluos программ хангамж ашигладаг байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 425,553.6 мянган төгрөгөөс тооцон 8,511.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10,391.4 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,249.0 мянган төгрөгөөр буюу 13.49 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө	0	0	0	
Авлага	11700.0	0	-11700.0	100.0
Урьдчилгаа	0	0	0	
Бараа материал	8,407.5	5,361.9	-3045.6	-36.22
Үндсэн хөрөнгө	587,564.2	666,813.2	79249.0	13.49
Хуримтлагдсан элэгдэл	-141,386.7	-144,910.2	-3523.5	
Нийт хөрөнгө	466,285.0	527,264.9	60,979.9	13.08
Өр төлбөр	0.0	-		
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	466,285.0	527,264.9	60,979.9	13.08
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	466,285.0	527,264.9	60,979.9	13.08

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 3,045.6 мянган төгрөгөөр буурсан нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон урьд онуудын бараа материалыг акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 79,249.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь НҮБ-ийн хүн амын сангаас 56,680.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, мөн 18,500.0 мянган төгрөгийн суудлын автомашиныг худалдан авсантай холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан улсын төсвөөс 323,170.4 мянган төгрөг урсгал зардалд зарцуулагдахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Аймгийн ЗДТГ-аас 24,777.0 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 172,844.6 мянган төгрөг, өөрийн орлого 696.0 мянган төгрөг нийт 198,317.6 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн 97,000.0 мянган төгрөгийг урсгал засварт, 1,180.0 мянган төгрөгийг нормативт зардалд, 3,232.8 мянган төгрөгийг тогтмол зардалд, 1,920.0 мянган төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 647.2 мянган төгрөгийг томилолтын зардалд, 10,889.2 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт, 83,448.3 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, нийт 198,317.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 10 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 58,152.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс санхүүгийн тайланд 32,468.4 мянган төгрөгийн дансны бичилтийг залруулж, 350.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 25,333.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Албан хаагч нарт нийт 230,5 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү олгосон байна. Тус газраас санхүүждэг “Аз жаргал” төвийн харилцахын баримтыг шалгахад 120,0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан байна. Энэ нь *ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан нэмэгдэл олгох тухай заалт болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”* гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Бараа материалын худалдан авалтын 67,6 хувь буюу 25,333.5 мянган төгрөгийн анхан шатны баримтад е-баримтыг хавсаргаагүй нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-тай тус*

тус нийцэхгүй байна.” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны мэдээллийг “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийх нийцлийн аудитаар шалгах болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Төрийн аудитын тухай хуулийн 18-р зүйлийн 18.4-т заасны дагуу 2018 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид **Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын** 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>20,107,530.00</u>	<u>5,361,975.88</u>
33	АВЛАГА	11,700,000.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	11,700,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,407,530.00	5,361,975.88
354	Хангамжийн материал	8,407,530.00	5,361,975.88
35410	Бичиг хэргийн материал	201,250.00	347,000.00
35420	Аж ахуйн материал	4,880,000.00	5,014,975.88
35470	Бусад хангамжийн материал	3,326,280.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>446,177,477.34</u>	<u>521,902,940.45</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	446,177,477.34	521,902,940.45
392	Биет хөрөнгө	379,782,060.57	455,432,523.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	339,106,587.80	339,106,587.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-7,053,130.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,000,000.00	18,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,000,000.00	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	113,557,924.68	131,633,124.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	-89,481,308.70	-92,914,458.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,114,706.24	107,513,447.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,515,849.45	-41,353,048.41
393	Биет бус хөрөнгө	66,395,416.77	66,470,416.77
39301	Програм хангамж	10,100,000.00	10,375,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,389,583.23	-3,589,583.23
39303	Бусад биет бус хөрөнгө	59,685,000.00	59,685,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>466,285,007.34</u>	<u>527,264,916.33</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>466,285,007.34</u>	<u>527,264,916.33</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	466,285,007.34	527,264,916.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	259,801,915.41	259,801,915.41
51101	Өмч: - төрийн	259,801,915.41	259,801,915.41
512	Хуримтлагдсан үр дүн	206,483,091.93	267,463,000.92
51210	Өмнөх үеийн үр дүн	206,483,091.93	206,483,091.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	60,979,908.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>466,285,007.34</u>	<u>527,264,916.33</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	385,682,884.00	580,553,121.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	59,065,121.61
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	59,065,121.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	59,065,121.61
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	59,065,121.61
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	162,754,014.00	213,190,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	222,928,870.00	308,297,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	162,754,014.00	198,317,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,531,014.00	24,777,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	98,223,000.00	172,844,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	696,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	14,872,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	14,872,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	425,553,657.90	519,573,212.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	425,553,657.90	519,573,212.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	419,924,357.90	517,164,172.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	147,594,412.00	159,170,000.00
210101	Үндсэн цалин	147,594,412.00	159,170,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,532,400.00	19,209,100.00
210201	Тэтгэврийн даатгал	12,701,600.00	13,162,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,469,400.00	1,457,901.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,175,400.00	1,208,299.00
210204	Ажилгүйдлийн даатгал	247,100.00	307,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,938,900.00	3,073,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,074,809.00	16,235,711.00
210301	Гэрэл, цахилгаан	4,150,000.00	4,158,693.00
210302	Түлш, халаалт	9,323,235.00	9,471,818.00
210303	Цэвэр, бохир ус	2,995,674.00	1,999,300.00
210304	Байрны түрээс	605,900.00	605,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,357,926.00	38,827,034.00
210401	Бичиг хэрэг	1,894,100.00	11,792,854.00
210402	Тээвэр, шатахуун	5,166,220.00	21,423,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,192,606.00	1,090,800.00
210404	Ном, хэвлэл	00.00	29,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	105,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	4,091,280.00
2105	Нормативт зардал	980,000.00	1,180,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	200,000.00
210502	Хоол, хүнс	980,000.00	980,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,809,810.07	83,336,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	244,200.00	336,600.00
210604	Урсгал засвар	4,565,610.07	83,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	876,800.00	7,457,600.00
210702	Дотоод албан томилолт	876,800.00	7,457,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,873,988.00	57,758,177.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,503,988.00	55,206,777.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	180,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,000.00	75,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	168,500.00	2,295,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,824,212.83	133,989,950.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	5,980,021.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	140,104,519.00	107,561,651.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,719,693.83	20,448,278.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,629,300.00	2,409,040.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,629,300.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	900,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,169,040.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,169,040.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	340,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	340,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-39,870,773.90	60,979,908.99
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-39,870,773.90	60,979,908.99

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	385,682,884.00	521,488,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,682,884.00	521,488,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	222,928,870.00	308,297,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	162,754,014.00	198,317,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,531,014.00	24,777,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	98,223,000.00	172,844,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	696,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	14,872,500.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	14,872,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	385,682,884.00	521,488,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	385,682,884.00	521,488,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,053,584.00	519,078,960.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,994,412.00	159,170,000.00
210101	Үндсэн цалин	146,994,412.00	159,170,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,579,200.00	19,209,100.00
210201	Тэтгэврийн даатгал	12,701,600.00	13,062,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,469,400.00	1,536,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,175,400.00	1,229,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	293,900.00	307,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,938,900.00	3,073,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,296,809.00	16,936,327.00
210301	Гэрэл, цахилгаан	4,150,000.00	3,940,004.00
210302	Түлш, халаалт	8,545,235.00	10,391,123.00
210303	Цэвэр, бохир ус	2,995,674.00	1,999,300.00
210304	Байрны түрээс	605,900.00	605,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,017,926.00	34,702,100.00
210401	Бичиг хэрэг	1,554,100.00	11,900,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,166,220.00	21,202,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,192,606.00	1,171,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	29,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	105,000.00	400,000.00
2105	Нормативт зардал	980,000.00	1,180,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	200,000.00
210502	Хоол, хүнс	980,000.00	980,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,898,680.00	103,336,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	244,200.00	336,600.00
210604	Урсгал засвар	4,654,480.00	103,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	876,800.00	7,457,600.00
210702	Дотоод албан томилолт	876,800.00	7,457,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,873,988.00	69,638,898.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,503,988.00	66,387,798.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	180,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,000.00	75,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	168,500.00	2,995,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	156,535,769.00	107,448,335.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	156,535,769.00	107,448,335.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,629,300.00	2,409,040.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,629,300.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	900,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,169,040.00

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,169,040.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	340,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	340,000.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,116,915.41	100,293,327.00	103,009,456.00	403,419,698.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	200,116,915.41	100,293,327.00	103,009,456.00	403,419,698.41
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,417,889.76	-6,417,889.76
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,801,915.41	00.00	206,483,091.93	466,285,007.34
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,801,915.41	00.00	206,483,091.93	466,285,007.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	259,801,915.41	00.00	206,483,091.93	466,285,007.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	60,979,908.99	60,979,908.99
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,801,915.41	00.00	267,463,000.92	527,264,916.33

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	323,170,400.00	321,661,360.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	323,170,400.00	321,661,360.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	322,270,400.00	320,761,360.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,170,000.00	159,170,000.00

210101	Үндсэн цалин	159,170,000.00	159,170,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,209,100.00	19,209,100.00
210201	Тэтгэврийн даатгал	13,062,100.00	13,062,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,536,800.00	1,536,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,229,400.00	1,229,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	307,400.00	307,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,073,400.00	3,073,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,872,500.00	13,703,460.00
210301	Гэрэл, цахилгаан	3,616,100.00	3,239,616.00
210302	Түлш, халаалт	8,717,800.00	7,925,244.00
210303	Цэвэр, бохир ус	1,932,700.00	1,932,700.00
210304	Байрны түрээс	605,900.00	605,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,782,100.00	32,782,100.00
210401	Бичиг хэрэг	11,900,000.00	11,900,000.00
210402	Тээвэр, шатахуун	19,682,100.00	19,682,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,171,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	29,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,336,600.00	6,336,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	336,600.00	336,600.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	6,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,961,000.00	6,810,400.00
210702	Дотоод албан томилолт	6,961,000.00	6,810,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,939,100.00	58,749,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,498,600.00	55,498,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	75,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,995,500.00	2,995,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24000000.00	24000000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,000,000.00	24,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	900000.00	900000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	900,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	323,170,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	323,170,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	323,170,400.00